



**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ХААГЧИЙН ТАНГАРАГ ӨРГӨХ ЁСЛОЛЫН АЖИЛЛАГАА

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1995 оны 109 дүгээр зарлигаар батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам”-ын дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын ажиллагаа 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 15.00 цагт Сайдын хурлын танхимд боллоо.

Ёслолын ажиллагаанд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Г.Саран, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Т.Гантогтох, Салбарын хяналтын газрын дарга Б.Санчирдорж, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Л.Идэрцогт, Мал эмнэлгийн ерөнхий газрын Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Б.Алтансүх нар оролцлоо.



Төрийн захиргааны албан хаагчаар томилогдсон Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Мал эмнэлгийн ерөнхий газар, Аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газрын нийт 13 төрийн захиргааны албан хаагч **“Эх орон, ард түмнийхээ төлөө эрдэм чадлаа зориулж, төрийн хууль, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж албан үүргээ үнэнч шударгаар биелүүлэхээ тангараглая. Тангарагаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ”** хэмээн Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөлөө.

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН
ЯАМНЫ ДЭРГЭДЭХ САЛБАР ЗӨВЛӨЛ**